

бүтээл, зураг болон цагаан толгойт авианы бичигт хүртэл ул мөрөө үлдээсэн, нэг талаас нь хараад шууд тайлбарлахад бэрх, нарийвчлан судлууштай, учир нь олдох зүйл болох нь илэрхий байна гэсэн дүгнэлт гарч ирж байна.

<sup>1</sup> Монгол Ардын Хувьсгалт Намын түүхэнд холбогдол бүхий зүйлүүд. УБ., 1928, 65 дахь тал

<sup>2</sup> Б. А. Истрин. Возникновение и развитие письма. М., 1965. , стр. 38-д үз

<sup>3</sup> Ф. Энгельс. Дюрингийн эсрэг, УБ., 1979, 43 дахь тал

<sup>4</sup> «Материалы по дешифровке киданского письма. I—II» (Москва, 1970)

<sup>5</sup> «Шинжлэх ухаан техник» УБ., 1957. 21 дэх тал

<sup>6</sup> О. Жамъян. «Урд өдрийн олиг үгийн бичиг» номдоо хятанг хятад гэж бичсэн нийг үзвэл хятан сийлбэр байж магадгүй. 205 дахь тал

<sup>7</sup> Х. Пэрлээ Монгол түмний гарлыг тамгаар хайж судлах нь» УБ., 1976, 205 дахь тал

<sup>8</sup> Х. Пэрлээ. Чинтолгойн бичигт ваар. УБ., 1959, 4 дэх тал

<sup>9</sup> А. А. Серкина. Опыт дешифровки древнейшего китайского письма «Наука», М., 1973, с.116-д үзмүү

<sup>10</sup> «Шинжлэх ухаан амьдрал» УБ., 1970, 16 дахь тал

**ХЯТАД ХЭЛНИЙ  
МЭНДЛЭХ ЗОЛГОХ, САЛЖ  
ХАГАЦАХ ЗАРИМ ҮГ  
ХЭЛЛЭГИЙН ТУХАЙ**

**Я. Ганбаатар**

Сүүлийн жилүүдэд БНХАУ дэлхийн тавцан дээр дахин гарч ирж өөрийн гэсэн байр сууриа эзэлсэн нь дэлхий дахинаа эртний түүх соёлтой энэ орныг сонирхон судлах хүсэл эрмэлзлийг зүй ёсоор хүчтэй сэргээсэн билээ. Үүний үрээр хятад судлалын ажил үйлс ихээхэн эрчимтэй явагдах боллоо. Сүүлийн үед манай оронд ч хятад судлал нэлээд идэвхжиж байна.

Хятад хэл бол олон мянган жилийн туршид бие даасан хэл-соёл болон хөгжиж ирсэн эртний баялаг хэлнүүдийн нэг юм. Тийм ч учраас гадаад дотоодын олон эрдэмтэн судлаачийн онцгой анхааран судалж буй нэг талбар болж байгаа нь маргаангүй. Харин манай улсад хятад хэл бичиг, уран зохиолыг тусгайлан судалж буй ажил хараахан эрчимтэй бус буюу ер нь хийсэн зүйл үгүй гэж хэлж болмоор байна. Иймд манай хятад судлаач эрдэмтэн мэргэд нэн ялангуяа шинэ залуу мэргэжилтнүүд энэ чиглэлээр судалж шинжлэх нөр их ажлыг эхлэх цаг болжээ. Энэ удаад хятад хэлний мэндлэх золгох, салж хагацахдаа хэлдэг, хэлцдэг үг хэллэгийн заримаас товч авч үзье. Энэхүү бяцхан өгүүлэлд нийт хятад хэлэндэх мэндлэх золгох, салж хагацах үг хэллэгийг бүгдийг цуглуулан жагсаах зорилт тавиагүй бөгөөд, зөвхөн өвөрмөц онцлог шинж бүхий тодорхой цөөн хэдэн үг хэллэгийг үндэсний зан заншил, угсаатны ёс зүйтэй нь холбон авч үзэж, тайлбарлахыг хичээлээ. Ер нь хятад хэлний дээрх төрлийн үг хэллэг үндэсний нэлээд өвөрмөц онцлогийг хадгалсан байдгийн зэ-

рэгцээ сүүлийн хэдэн арван жилд европ зүгийн хэлэн дэх дээрх төрлийн хэллэгийн хуулбар (орчуулга) гэмээр шинэ үг хэллэг ч бий болж байгааг дурьдах ёстой биз ээ.

Өдгөө хятад хүмүүс: ni hao? гэж хэлдэг нь монгол хэлний Та сайн байна уу? гэсэн мэндлэх үгтэй дүйх юм.

Энэ нь өнөөдөр өргөн хэрэглэгддэг жирийн мэндлэх үг боловч бүр МЭ VI-VIII зууны үе дэх Тан улсын их яруу найрагч Ли Бай, Дү Фу нарын үеэс зөвхөн бичиг номын хүмүүс, эрдэмт мэргэдийн дунд хэлэлцэх мэндийн үг болж хэрэглэгдэх болсон нь өнөө ч энэ шинжээ алдаагүй хэвээр байна. Харин түүхийн харьцангуй хожуу үед, тухайлбал энэ зууны эхэн буюу дунд үест нийгэм соёлын хувьсал дэвшил, гадаад харилцааны өргөжилт хөгжилтэй холбоотойгоор нэлээд өргөн хэрэглэгдэх болж байна.

Урьд цагт хятад хүмүүс өөр үгээр мэндэлдэг байжээ. Жишээлбэл: Chi fan le ma? Хоолоо идсэн үү? гэж мэндэлдэг байсан нь урьд цагт эгэл жирийн ард түмэн ядуу дорой, өлөн зэлмүүн аж төрж байсны тусгал бөгөөд тэр цагт хүн хоол идсэн, ходоодондоо л «юм»-тай явбал сая аз жаргалтай, амар жимэр сайн сайхан байна гэсэн ойлголтыг илэрхийлж байжээ. Тэгээд ч «хоолоо идсэн үү?» гэдэг энэ үг маань зөвхөн хоол идсэн идээгүйн төдий хэрэг бус, бүр өргөн утгаараа «Сайн байна уу» хэмээн амар мэнд, аз жаргалыг асууж мэдэх гэсэн утгатай байна. Хариуд нь хоол идээгүй байлаа ч: Chi fan le Хоолоо идсэн гэж хариулдаг. Хариулагч этгээд энэ тохиолдолд үнэхээр хоол идсэн эсэх нь чухал бус. Яагаад гэвэл цаад хүн түүний амрыг айлтгаж байгаа болохоос биш хоол идсэн үгүйг нь асуусан хэрэг ер биш юм. Өнөө хэр нь танил дотно хүмүүс, ахмад настайчууд, хөдөөгийн ард иргэд ингэж мэндэлдэг байна.

Европ зүгийн ард түмнүүдийн мэндлэх золгох, салж хагацах үг хэллэг олон янз байдаг. Өглөө (босоод) уулзаад: -Өглөөний мэнд (хүргэе!) «Тавтай нойрсов уу?» гээд энэ мэт -Өдрийн мэнд!, Оройн мэнд!, Сайхан нойрсоорой! гэх зэрэг олон үг хэллэг бий. Хятад хэлэнд ч эдгээртэй дүйх үг хэллэг бий боловч жинхэнэ хятад хүний сэтгэхүйн үүднээс хятад хүмүүс хэлж ярьдаг үгс бус, өнөөх нийгэм, соёлын хөгжил хувьсал, гадаад харилцааны өргөжих явцад хариас орж ирсэн «харь ухагдахуун», түүнд оноосон үг хэллэг юм. Эдгээр нь: Zao an! өглөөний мэнд!

Zao shang hao! өглөөний амгаланг айлтгая!

Wan shang hao! оройн (үдшийн) амгаланг айлтгая!

Wan an! оройн мэнд! гэх мэтийн хэллэг байгаа бөгөөд

«Тавтай нойрсов уу? Өдрийн мэнд!» гэх мэтэд дүйх хэллэг одоогоор үгүй байна.

Эдгээрийн оронд урьд цагт хятад хэлний мэндлэх золгох, салж хагацах үгс нэг бол маш энгийн эгэл жирийн, эсвэл ёс төрийг эрхэмлэдэг хятад хүний нарийн нандин журам ёсны дагуу эрхэмсэг дээд найруулгын аястай үг хэллэг байжээ. Одоо ч тэдгээрийг өргөн хэрэглэдэг юм. Жишээлбэл: хятад хүмүүс гадаа гудамжинд уулзвал: Ni qu nar?-Хаа хүрч явна! (Хаачих нь вэ? Аль хүрч явна даа?) гэдэг нь нэг ёсны мэндчилгээ ажээ. Монголчууд ч бас танил дотно хүнтэйгээ тааралдахдаа тэр болгон «Сайн байна уу?» гээд байдаггүй, шууд Хаа хүрч явна? гэж мэндэлдэг билээ. Ер нь монголчууд урьд цагт, уулзсан хүнээсээ: Сайн байна уу? гэж асууж байсангүй, нарийн утга учир бүхий маш өвөрмөц сайхан үгс хэлэлцдэг байсны дотор дээрх утгыг илэрхийлсэн: Хэрэг зориг юунд вэ? (Хэт нутаг хаана вэ?) гэх зэрэг үгс нь мэндлэх хүндлэх ёсыг шингээсэн уран яруу хэллэг юм.

Хятад хэлээр мөн Ni zao lai le? Та эрт ирэв үү?, Ni dao naг qu ya? Та хаа хүрч явна?, Mai dong xi ya? Юм авч явна уу? (дэлгүүр, зах зээлд тааралдах үед) гэх зэргээр мэндчилдэг нь цаад хүнийхээ юу хийж байгаа, хаашаа яах гэж явааг мэдэх зорилго огт тавиагүй, ердөө л амар мэндийг нь асууж байгаа хэрэг юм. Хариуд нь: Chu qu yi xiar? Салхилж явна, Dao wai bian zou zou Зугаалж явна, Qu shang dian Зүгээр л дэлгүүр орж явна гэх мэтээр хариулдаг. Энэ нь монгол хэлний аман ярианы: Юу байна? (Сонин юу байна?), Юу хийж байна?, Ажлаа хийж байгаа юу?, Хичээлдээ явж байгаа юу?, Хаачиж явна? гэх зэрэг үгтэй таарч байна.

Түүнчлэн аль нэг газар, ажил, албан байгууллага, ер нь нэг дор ажилладаг, сурдаг, аж төрдөг хүмүүс нэгийгээ ирэхэд Ni lai le гэдэг нь Та ирэв үү?, Хүрээд ирэв үү, гэсэн утгатай бас л мэндчилгээ юм. Монгол хэлний ийм хэллэг ч бас этгээд бус бөгөөд бид үргэлж хамт байдаг, үргэлж уулзаж, учирдаг хүнээ ирэхэд нь тэр болгон «Сайн байна уу?» гээд байдаггүй, харин «Өө, та (чи) хүрээд ирэв үү?» гэх зэргээр учран үг хэлцдэгтэй адил аж.

Хятад хүмүүс: Zai jian! баяртай! (үгчилбэл дахин уулзъя! гэсэн үг) гэдэг үгийг ч тэр бүр хэлдэггүй. Ni zou le ma? Та явлаа юу? гэхэд хариуд нь Wo zou! Би явлаа! гэдэг нь «Баяртай» гэж харилцан ёс үйлдэж буй энэ хэллэг одоо ч түгээмэл юм. Энэ мэт хэллэгээс гадна харилцагч хүмүүс тухайн цаг үе, нөхцөл байдалд юу хийж эрхэлж хаана, хаашаа явж сууж байгаагаас үүдэн мэндлэх золгох, салж хагацах онцлог утга агуулга бүхий үг хэллэг байдаг. Жишээлбэл: алив баяр ёслол, найр наадмын үеэр уулзаж учрах үед: Guo jie gi hao ma? -Сайхан баярлаж байна уу? гэх зэргээр мэндчилдэг нь манайхтай их адилхан байна. Ер нь монголчуудын «Хожил хоёр тийшээ (болтугай!) «Үйл уран болтугай!», «Сайхан зусч байна уу?», «Мал сүрэг тарган, тавтай сайхан өвөлжиж байна уу?» гэх мэт зан үйлийн холбогдолтой ерөөлийн үгс ч мэндчилгээний нэг хэлбэр бөгөөд энэ тухай «Монголчуудын мэндлэх хүндлэх ёс» номонд тодорхой байдаг билээ.

Цаашилбал, хятад хүмүүс, зочныг явахад нь: Man zou! Man manг zou! гэж хэлдэг нь үгчилбэл: Аажуу тайван яваарай! гэсэн үг боловч мөн л -Баяртай, сайн яваарай! гэсэн утгатай юм. Энэ мэт, You kong zai lai wangr! Завтай цагтаа ирж байгаарай! гэхэд Ma fan bu liao ni! Төвөг удах биз дээ!, Bu yuan song ni le!

Хол гаргаж өгч чадсангүй дээ! гэхэд Qing hui, qing hui! Буц! буц! Буц даа?! гэх зэргээр хариулдаг нь бүгд л салах ёсны үг хэлж буй нь тэр юм.

Ийнхүү, хятад хэлний дээрх төрлийн үг хэллэгийн заримаас товчхон авч үзэхэд ийм байна.

<sup>1</sup> Жан Сяожун, Тянь Шици «Хятад ярианы хэл» Бээжин хот, 1988 он

<sup>2</sup> «Хятад ярианы хэл», Бээжин 1989

<sup>3</sup> «Хятад монгол толь» Бээжин 1983

<sup>4</sup> «Синьхуадацыдянь» 1985